



ДУНДГОВЬ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН
ТОГТООЛ

2021 оны 03 сарын 03 өдөр

Дугаар 43

Мандалговь

Автомашинд үнэлгээ тогтоож,
худалдах зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.2, 77.3, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2020 оны 30 дугаар тогтоолоор батлагдсан “Орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ийн 1 дүгээр зүйлийн 1.2 дахь хэсэг, 6 дугаар зүйлийн 6.2 дахь хэсгийн 6.2.1, 6.4 дэх хэсгийн 6.4.1 дэх заалтуудыг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ НЬ:

Нэг: Аймгийн Засаг даргын тамгын газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй 40,000,000 /дөчин сая/ төгрөгийн балансын үнэтэй, үлдэгдэл өртөггүй ДУЭ 00-04 улсын дугаартай TOYOTA land cruizer маркийн автомашины худалдах доод үнийг 10,000,000 /арван сая/ төгрөгөөр тогтоон нээлттэй дуудлага худалдаагаар худалдахыг зөвшөөрсүгэй.

Хоёр: Эд хөрөнгийг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу худалдаж, хөрөнгө худалдсанаас орох орлогыг орон нутгийн хөрөнгө борлуулсны орлогын 100080000962 тоот дансанд бүрэн төвлөрүүлэхийг Орон нутгийн өмчийн газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Ж.Гантулга)-д үүрэг болгосугай.

Гурав: Эд хөрөнгийг худалдсаны дараа холбогдох хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэхийг Аймгийн Засаг даргын тамгын газрын дарга /Л.Доржбат/-д даалгасугай.

Дөрөв: Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг дарга (Ц.Мөнхбат)-д үүрэг болгосугай.

ДАРГА



С.ОД-ЭРДЭНЭ

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
Тэргүүлэгчдийн 2021 оны 03 дугаар сарын
03-ний өдрийн 13 тогтоолын хавсралт

Аймгийн ЗДТГ-ын дуудлагаар худалдах тээврийн хэрэгслийн мэдээлэл

№	Тээврийн хэрэгслийн төрөл	Марк	Улсын бүртгэлийн		Удирдсан нөсөр	Ашиглалтад орсон огноо	Тээврийн хэрэгслийн		Нийт гүйлт /км/	Балансын үнэ	Хуримтлагдсан эзлэгдэл	Үлдэгдэл өртөг	Данснаас хасах болсон шалтгаан	
			сери	дугаар			арлын дугаар	моторын эзлэхүүн						
1	Суудал	Тоёота ланд круйзер-100	ДУЭ	00-04	1999	2009.07.20	HPJ81010016818	B4163	242,788	40,000,000.00	40,000,000.00	-	Ашиглалтын шаардлага хангахгүй болсон	
ДҮН											40,000,000.00	40,000,000.00	-	